



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2024/10-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2024 он	Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsoqjargalb@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	8
3.1 Албан шаардлага	8
3.2 Зөвлөмж	8
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	9

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.03.25 № 169
танай _____-ны № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ХОТОНТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТБААТАР
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Хотонт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөг эс тооцвол Хотонт сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитаар илэрсэн доорх алдаа зөрчил нь материаллаг боловч санхүүгийн тайланд үзүүлэх үр нөлөө нь өргөн тархаагүй тул Хязгаарлалттай дүгнэлт хүргүүлж байна. Үүнд:

- Газрын дуудлага худалдааны орлогыг үндэслэлтэй төлөвлөөгүйгээс 53,928.2 мянган төгрөгийн орлого дутуу төвлөрсөн.
- Хоршоо хөгжүүлэх санд 32 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн нийт 83,600.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Тайланд онд шилэн дансны цахим системд мэдээлбэл зохих 30 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 41.2.1, Шилэн дансны тухай хуулийн 4.1.3, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон

шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.11, 11.3 дахь заалтыг зөрчсөн, аудитын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

МУЗГ-ын 2022 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тус орлогыг тайлант оноос захиран зарцуулж, тайлагнах болсон байна.

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн 15 үндсэн зорилтын хүрээнд 131 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 80.46 хувийн гүйцэтгэлтэй үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	580,410.9	662,375.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	121,448.3	251,949.7
33	АВЛАГА	415,357.3	362,946.4
35	БАРАА МАТЕРИАЛ	43,605.3	47,479.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,178,854.6	2,392,234.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,178,854.6	2,392,234.8
39200	Биет хөрөнгө	2,138,844.6	2,352,224.8
39300	Биет бус хөрөнгө	40,010.0	40,010.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,759,265.5	3,054,610.2
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,340.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	2,340.0
41300	Өглөг	0.0	2,340.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,759,265.5	3,052,270.2
51	Засгийн газрын хувь оролцоо	2,759,265.5	3,052,270.2
51100	Засгийн газрын оруулсан капитал	545,657.5	545,657.5
51200	Хуримтлагдсан үр дүн	1,340,275.6	1,633,280.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	873,332.5	873,332.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,759,265.5	3,054,610.2

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,081,149.2	1,713,140.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	533,857.8	562,837.7
110	Орлогын албан татвар	268,914.2	336,591.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	268,914.2	336,542.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	49.5
113	Хөрөнгийн албан татвар	54,361.2	106,110.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	210,582.5	120,135.4
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	114,704.5	416,702.3
120	Нийтлэг татварын бус орлого	114,704.5	416,702.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,432,586.9	733,600.2
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,912,380.5	1,106,730.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,912,380.5	1,106,730.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	933,690.9	1,083,830.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,726.5	479,061.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,615.6	59,765.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,868.5	24,693.6
2104	Хангамж, бараа материалын зардал	48,202.7	68,165.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,561.4	7,815.3

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2107	Томилолт, зочны зардал	2,950.0	4,766.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,408.0	194,172.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	223,358.2	245,391.0
211	ХҮҮ	0.0	0.0
212	ТАТААС	0.0	0.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	978,689.6	22,900.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.0	0.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	168,768.7	606,409.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	4,634,097.7	313,285.0
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-4,465,329.0	293,124.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,114,578.1	1,434,998.5
11	ТАТВАРЫН ОРЛОГО	533,737.8	562,837.7
110	Орлогын албан татвар	268,914.2	336,591.8
1100	Хувь хүний орлогын албан татвар	268,914.2	336,542.2
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	0.0	49.5
113	Хөрөнгийн албан татвар	54,241.2	106,110.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	210,582.5	120,135.4
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,798.4	15,204.6
1181	Газрын төлбөр	173,678.6	45,352.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	26,105.6	59,578.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	148,253.4	136,220.6
120	Нийтлэг татварын бус орлого	148,253.4	136,220.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,432,586.9	735,940.2
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,745,843.4	911,210.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,745,843.4	911,210.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	767,153.8	886,710.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,696.5	477,870.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,645.6	58,635.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,868.5	24,693.6
2104	Хангамж, бараа материалын зардал	44,362.9	51,973.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,069.3	7,800.0
2107	Томилолт, зочны зардал	2,950.0	4,766.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,408.0	196,097.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	61,153.0	64,875.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	978,689.6	24,500.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	368,734.7	523,788.2
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	167,252.1	318,286.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	167,252.1	318,286.8
2200	Дотоод эх үүсвэрээр	167,252.1	318,286.8

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-167,252.1	-318,286.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-155,000.0	-75,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	155,000.0	75,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	46,482.6	130,501.4
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	74,965.6	121,448.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	121,448.3	251,949.7

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,308,040.9	7,308,040.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-83,446.3	-83,446.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,224,594.6	7,224,594.6
9	Тайлант үеийн үр дүн	-4,465,329.0	-4,465,329.0
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,759,265.5	2,759,265.5
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,759,265.5	2,759,265.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-120.0	-120.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,759,145.5	2,759,145.5
19	Тайлант үеийн үр дүн	293,124.7	293,124.7
20	2023 оны 6-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,052,270.2	3,052,270.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,829,078.50	1,293,134.30	535,944.20	70.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	920,425.20	899,847.50	20,577.70	96.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	895,925.20	875,347.50	20,577.70	96.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	486,992.40	477,870.20	9,122.20	97.89
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	60,874.00	58,635.00	2,239.00	97.27
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	192,011.90	183,408.80	8,603.10	95.34
2104	Хангамж, бараа материалын зардал	48,580.00	48,526.80	53.20	98.41
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	22,859.40	22,859.40	0.00	98.87
2107	Томилолт, зочны зардал	5,300.00	4,766.00	534.00	99.85

Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,719.90	14,706.00	13.90	97.37
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,587.60	64,575.40	12.20	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,500.00	24,500.00	0.00	100.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг			0.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	24,500.00	24,500.00	0.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	663,493.30	318,286.80	345,206.50	50.65
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	245,160.00	75,000.00	170,160.00	90.86
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,829,078.50	1,317,909.80	511,168.70	85.99
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,258,668.60	1,219,505.60	39,163.00	94.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	570,409.90	98,404.20	472,005.70	31.68
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	89,697.80	-89,697.80	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	100,911.60	-100,911.60	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	58	58		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	28	28		
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	28	28		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	12,330.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	12,330.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>11,362.742,330.1</u>
2104	Хангамж, бараа материалын зардал	<u>589.73,446.2</u>
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	<u>7,616.541,283.3</u>
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	<u>300.0457.4</u>
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	<u>11,362.742,330.1</u>
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	<u>11,362.742,330.1</u>

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт 137,528.2 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

5.1.1 Сумын төсвийн орлого нийт дүнгээр давж биелсэн боловч гүйцэтгэлээр газрын дуудлага худалдааны орлого 53,928.2 мянган төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5.1.2 Тайлант онд Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс 2,014.4 мянган төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлсэн гэж тайлагнасан бөгөөд үйл ажиллагааны зардалд 3,840.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 2 дугаар зүйлийн 2.7.”Сангаас олгосон зээлийн хүүгийн өмнөх жилийн орлогын 30 хүртэл хувийг хоршоонд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хүртэл хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаа болон программ хангамжийн зардалд, 10 хүртэл хувийг аймгийн жижиг, дунд үйлдвэрийн бодлогын хэрэгжилт хариуцсан байгууллагын саналыг харгалзан сумын хоршоо, жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнийг урамшуулахад зориулан хууль тогтоомжид нийцүүлэн зарцуулж болно” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

3.2 Зөвлөмж

3.2.1 Хоршоо хөгжүүлэх сантай холбоотой

Илрүүлэлт: Хоршоо хөгжүүлэх санд 32 зээлдэгчтэй холбоотой хугацаа хэтэрсэн 77,707.0 мянган төгрөгийн үндсэн зээл, 5,893.0 мянган төгрөгийн хүү нийт 83,600.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулах талаар үр дүнтэй арга хэмжээ авч, зээлийн эргэн төлөлтөд хяналт тавьж ажиллах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэсэн заалтын дагуу зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2024 оны 04 дугаарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хугацаа хэтэрсэн зээлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	83,600.0	-	-	-	-	1	83,600.0	-	-	-	-	-
Орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллаагүй байна.	1	53,928.2	-	-	1	53,928.2							
ХХС-ийн үйл ажиллагааны зардалд журамд заасан хувиас илүү дүнгээр зарцуулсан байна.	1	0.0	-	-	1	0.0							
Нийт дүн	3	137,528.2			2	53,928.2	1	83,600.0					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Үүнээс							
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил										
Шилэн дансны системд мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан	1	0					1	0		
Дүн	1	0					1	0		